



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/ЧЧ

Улаанбаатар хот

“Улаанбаатар” аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 18.2.1, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/322 дугаар захирамж, газрын 2017 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 1.4.9.3, газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монгол аялагчдад эх орноороо болон гадаад улсад аялах боломжтой байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газруудын талаар нэгдсэн мэдээлэл, олгох, зөв зохистой аялах талаар зөвлөмж өгөх зорилго бүхий “Улаанбаатар” аялал жуулчлалын үзэсгэлэнг 2017 оны 6 дугаар сарын 03,04-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулахыг Бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн /Н.Алтанзаяа/-даалгасугай.

2. “Улаанбаатар” аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулахад шаардагдах удирдамжийг нэгдүгээр хавсралт, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 19 633 000 /Арван есөн сая зургаан зуун гучин гурван мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-т зөвшөөрсүгэй.



1150500179

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 05 сарын 18
өдрийн 6 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

1117139265
УОА0453 5284325

“УЛААНБААТАР” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

НЭГ.ЗОРИЛГО

Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, монгол аялагчдад эх орны байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын дурсгалт газруудын талаар нэгдсэн мэдээлэл олгох, зөв зохистой аялах, ямар маршрутаар хаашаа, яаж аялах талаар зөвлөмж олгох зорилгоор тус үзэсгэлэнг зохион байгуулж байна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Тус үзэсгэлэнд Монгол улсад суугаа гадаад улсуудын ЭСЯ, дипломат төлөөлөгчийн газрууд, 21 аймгийн аялал жуулчлалын газрууд, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаад, дотоодын болон гадагшаа чиглэсэн аяллын (outbound) тур оператор, тур агент компаниуд, тээвэр, даатгал, банк, шатахуун түгээх станцууд, аяллын техник хэрэгслийн компаниуд, амралт, рашаан сувиллын газрууд, зочид буудал, зоогийн газрууд, аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, аяллын клубууд, соёл урлаг, үзвэрийн газрууд, аялал жуулчлалын чиглэлийн бизнес эрхлэгчид хамрагдана.

Мөн үзэсгэлэнгийн үеэр зохион байгуулагдах аяллын сургалт, лекц семинар болон төрөл бүрийн арга хэмжээнүүдэд оролцох боломжтой.

ГУРАВ.ХУГАЦАА, ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР

2017 оны 6 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд болно.

ДӨРӨВ.УРИА

“Аялал бүхэн аз жаргалтай” гэсэн уриан доор зохион байгуулна.

ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

Ерөнхий зохион байгуулагч:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

Нийслэлийн Аялал жуулчлалын газар

“Улаанбаатар аялал жуулчлалын холбоо” ТББ

Хамтран зохион байгуулагч:

Байгаль орчин, Аялал жуулчлалын яам

Нийслэлийн Соёл урлагийн газар

ЗУРГАА.ҮЗЭСГЭЛЭНГИЙН ҮЕЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АЖЛУУД

Төв тайzan дээр болох арга хэмжээнүүд:

- Нээлт, хаалтын ажиллагаа, урлагийн тоглолт
- АХА тэмцээн /аялал жуулчлалын холбогдолтой/
- Хамтран ажиллагч байгууллагуудын танилцуулга мэдээлэл
- Аяллын холбогдолтой лекц унших – мэргэшсэн багш нар /дугуй, авто, уул, фото, анхан шатны тусламж үзүүлэх тухай, хээрийн хоолыг хэрхэн бэлтгэх талаар, загасчлах, зөв хувцаслалт, аялагчдын соёлын асуудлын тухай, гадаадад аялагчдад өгөх зөвлөмж/

Байгууллагуудын өөрийн стэнд дээр болох арга хэмжээнүүд:

- Элчин сайдын яамдууд улс орноо сурталчлах, таниулах
- 21 Аймгийн аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд аймгийн зорих газрууд болон бусад мэдээллийг өгөх
- Орон нутгийн Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаад өөрсдийн үйл ажиллагаа болон газар орныхоо талаарх мэдээллийг өгөх
- Аяллын хувцас, төрөл бүрийн хэрэгслүүдийн үзэсгэлэн, хямдралтай худалдаа зохион байгуулах , аяллын тоног хэрэгслийн түрээсийн үйлчилгээ
- Аялал жуулчлалын салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн танилцуулга, мэдээлэл өгөх
- Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид иргэд, жуулчдад өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох, борлуулах
- Хоол, ундны үйлчилгээ
- Аутбаунд тур оператор, тур агент компаниуд, тээвэр, даатгал, банк, үүрэн холбооны операторууд, шатахуун түгээх станцууд, аяллын техник хэрэгслийн компани, амралт, рашаан сувиллын газрууд, зочид буудал, зоогийн газрууд, аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, аяллын клубууд, соёл урлаг, үзвэрийн газрууд өөрсдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах
- Флаш моб үзүүлбэр, авто зөвлөгөө, шоу, бусад

ДОЛОО.МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА

Үзэсгэлэнгийн арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулна. Сошиал маркетинг хийх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, фм-ээр сурталчилгаа явуулна.

НАЙМ.ҮР ДҮН

Дотоодын аялагч иргэд, жуулчид зүй зохистой аялах талаар мэдлэгтэй болох, нийслэлээс хөдөө орон нутгийг зорих дотоодын иргэд нэгдсэн мэдээлэлтэй болох, дотоодын аялагчдын тоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын бизнесийг дэмжих, тэдгээрийн хамтын ажиллагааг бий болгох, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг болсон байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 05. сарын 10. өдрийн 11:11 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

“УЛААНБААТАР” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА

2017 оны 05 дугаар сарын 18

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо, хэмжээ	Нэгж үнэ	Хянасан
1	Тайз засал /пед дэлгэц, хөгжмийн түрээс/	2 /өдөр/	1 500 000	3 000 000
2	Майхны түрээс (5x5м ²) 2 хоног	10	120 000	1 200 000
3	Майхны түрээс (3x3м ²) 2 хоног	10	100 000	1 000 000
4	Сандал, ширээ түрээс	80 ш	5 000	400 000
5	Хэвлэмэл материал /үзэсгэлэнгийн зорилго, хөтөлбөр, оролцогчдын мэдээлэл бүхий/	1000	400	400 000
6	Маркетинг сурталчилгааны зардал /мэдээллийн цуврал мэдээ, шторк хийлгэх, идэвхжүүлэх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсээр цацах/	Шторк хийлгэх 20-30 сек	1 500 000	1 500 000
		Үзэсгэлэнгийн үеэр хийгдэх видео болон дрон бичлэг, фото зураг авах, нэвтрүүлэг бэлдэх 1 удаа	3 000 000	3 000 000
		Сошиал пейж хуудсаар бүүст хийж идэвхжүүлэх /14 хоног/ 60-250 мянган хандалтай хуудсуудаар	2 000 000 /MongolHD, Боловсрол тв, UBS тв/-ний 10 өдөр оргил цагуудаар 2-4 удаа	2 000 000
		Шторк болон нэвтрүүлгийг телевизээр 5 хоног, шторкыг 3 фм-ээр 5 хоног тус тус цацах		
7	Хөтлөгч 2 өдөр	2	800 000	1 600 000
8	Урлагийн тогтолт	2 өдөр 6 удаа	300 000	1 800 000
9	Туслах ажилчдын цалин	10 хүн /2 өдөр/	15 000	300 000
10	Лекц унших багш нарын цалин	10	100 000	1 000 000
11	Цахилгаан татах	2 өдөр	250 000	500 000
12	Хөмсгөн хаяг	5x0, 3=10 ш 3x0, 3=10 ш	9000 5400	144 000
13	Мандат хэвлэлт /гэр, оосор/	100	1 000	100 000
14	Гадна талбай дахь хөтөлбөр хэвлүүлэх /хөлтэй баннер/	4	124 500	498 000

15	Гадна самбарт баннер хэвлүүлэх, байршуулах / Д.Сүхбаатарын талбайн урд/	18x6м*1м ² =8250 1 өдөр= 150 000*2 хоног	891 000 300 000	1 191 000
НИЙТ			19 633 000	

--оо0оо--

ХЯНАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:
ДОТООДЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХӨГЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *H.Алтанзаяа* Н.АЛТАНЗАЯА